

НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтын

2023 оны 5-р сарын тайлан мэдээ

2023.05.30

Улаанбаатар хот

| № | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | 2023 оны IV сарын хэрэгжилтийн үр дүнгийн тухай мэдээлэл | Хэрэгжилтийн үнэлгээ | 30 болон 0 үнэлгээтэй бол удааширсан шалтгаан | | | | | Хэрэгжилтийн явц | | | | | |
|---|----------------------------------|---------------------------|---|----------------------|---|----|----|---|---|------------------|----------------------|-----------------------|-----------------|----------------------|---------------------|
| | | | | | 100 | 70 | 30 | 0 | И | | | | | | |
| | | | | санхүүжилтээс | 100 | 70 | 30 | 0 | И | Х | Зохион байгуулалтаас | Үрг тухцаанд хэрэгжих | Бүрэн хэрэгжсэн | Тодорхой ахин гарсан | Ажил огт хийгдээгүй |

3Г-ЫН ТОГТООЛ

| | | | | | | | | | |
|---|---|--|--|---|--|--|--|--|---|
| | | | | | | | | | |
| 1 | Авто замын төлбөр хураах цэгийг цахимжуулах арга хэмжээний тухай 2022-08-10 Дугаар 2022_302 | 3.Төлбөр хураах цэгийг цахимжуулах ажлыг шуурхай зохион байгуулах арга хэмжээ авч, хот орчмын төлбөр хураах цэгийг 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор ашиглалтад оруулахаар тооцож ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай. | Нийслэлийн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодын цахим төлбөрийн системд буруу танигдсан тээврийн хэрэгсэлд нэхэмжлэл илгээх товчийг товчоодын төлбөр авах цэгийн ажилтнууд давхар хянаж илгээх боломжтой болсон. 2023 оны 5-р сарын байдлаар Нийслэлийн шалган нэвтрүүлэх 4 товчоодоор 392,070 тээврийн хэрэгсэл нэвтэрснээс орон нутгийн тээврийн хэрэгсэл 45,317 нэвтэрсэн харин орон нутгаас Улаанбаатар хот руу орох тээврийн хэрэгслээс авах төлбөрийн нэхэмжлэх дүн нь 69,254,000 төгрөг байна. | + | | | | | + |

| | | | | | | | | | | | |
|---|---|--|--|---|--|--|--|--|--|--|---|
| | | | | | | | | | | | |
| 2 | Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419 | 9. Төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээнүүдийг нэгтгэж, мэдээлэл солилцооны цахим шилжилтийг нэвтрүүлэх арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд, холбогдох мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумьяабазар нарт даалгасугай. | "Онлайн бизнес төв" системийг ашиглан 2023 оны 5-р сарын байдлаар 447,438 иргэн аж ахуй нэгж байгууллага хандаж 12,635 хүсэлтийг ирүүлснээс зөвшөөрсөн 8,405 хүсэлтийг батлуулахаар шилжүүлсэн болон шийдвэрлэсэн төлөвтэй үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө аваад байна. | + | | | | | | | + |
| 3 | Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68 | 7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан "Цахим аймаг" болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газраас дэвшиүүлсэн Цахим үндэстэн болох зорилт, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудын хүрээнд төрийн үйлчилгээний шат дараалал, авлига хүнд суртал, авто замын түгжэрл, иргэдийн аюулгүй байдал зэрэг Улаанбаатар хотод тулгамдаж буй асуудлуудыг технологийн тусламжтайгаар шийдвэрлэхээр "Цахим засаглал", "Зам тээврийн нэгдсэн систем", "Аюулгүй хот" дэд төслийд 2017-2023 онд холбогдох чиг үүргийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна. Үүнд: 1. Нийслэлд үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжид УБЗАА болон 9 дүүргийн Худалдаа үйлчилгээний хэлтсээс | + | | | | | | | + |

| | | | | | | |
|--|--|---|--|--|--|--|
| | | <p>олгодог зөвшөөрөл болон зөвшөөрлийн шинжтэй үйл ажиллагаа эрхлэх 134 нэр төрлийн үйлчилгээг цахимжуулж, төрийн үйлчилгээний операторын нэгдсэн портал www.e-mongolia.mn системийн дэд систем болох Бизнесийн орчин дахь төрийн үйлчилгээг цахимжуулах "E-Business" платформд 134 үйлчилгээг холбосон.</p> <p>2.Нийслэлийн ойр орчмын шалган нэвтрүүлэх 4 товchood /Баруун түрүүн, Налайх Тэрэлж, Түргэний гол, Эмзэлт/-ын төлбөр авах цэгт цахим төлбөрийн системийг нэвтрүүлсэн.</p> <p>3.Нийслэлийн 9 дүүргийн 204 хороодын 1872 хэсгийн ахлагчийн үйл үйл ажиллагааг цахимжуулах "Хэсгийн ахлагчийн систем"-ийг 2023 оны 1-р улиралд хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд орчны зөрчил мэдээлэх, айл өрх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад мэдээ мэдээллийг хүргэх зохион байгуулалтын үйл ажиллагааны ажлуудыг цахимжуулсан.</p> <p>4.Нийслэлийн төрийн байгууллагуудын уламжлалт цаасан суурьт үйл ажиллагаанд шинэчлэлт хийх замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэн, байгууллага нэгжүүдийн уялдаа холбоо, мэдээллийн урсгалыг сайжруулах нийслэлийн дотоод удирдлагын UBERP системийг нэвтрүүлж, энэхүү системийг нийслэлийн 1200 орчим байгууллага 30,000 гаруй албан хаагч ашиглаж өдөр тутмын үйл ажиллагаагаа 100% цахимаар гүйцэтгэж байна.</p> <p>5 Архив, албан бичиг хөтөлтийн https://edoc.ulaaanbaatar.mn/ системийг ашиглан нийслэлийн нутгийн захиргааны 996</p> | | | | |
|--|--|---|--|--|--|--|

| | | | | | | | | | |
|--|--|---|--|--|--|--|--|--|--|
| | | <p>байгууллага /нийслэлийн 9 дүүрэг, хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газар/-ын 14077 албан хаагч тамга тэмдэг дараах эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр албан бичиг илгээж солилцдог бөгөөд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хоорондын албан бичгийн харилцааг 100% цахимжуулсан.</p> <p>6. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/207 дугаар захирамжийн дагуу “Авто тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээ (RFID tag)-г суурилуулах” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компанийтай гэрээ байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд Нийслэлийн хэмжээнд 100 цэгээр дамжуулан 442477 ширхэг цахим гэрчилгээг тээврийн хэрэгсэлд 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн суурилуулахаар төлөвлөж байна.</p> | | | | | | | |
|--|--|---|--|--|--|--|--|--|--|

ЗГ-ын хуралдааны тэмдэглэл

| | | | | | | | | | | | |
|---|---|--|---|---|--|--|--|--|--|--|---|
| 4 | 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11 | XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг хапах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн | “Онлайн бизнес төв” системийг ашиглан 2023 оны 5-р сарын байдлаар 447,438 иргэн аж ахуй нэгж байгууллага хандаж 12,635 хүсэлтийг ирүүлснээс зөвшөөрсөн 8,405 хүсэлтийг батлуулахаар шилжүүлсэн болон шийдвэрлэсэн төлөвтэй үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө аваад байна. | + | | | | | | | + |
|---|---|--|---|---|--|--|--|--|--|--|---|

| | | | | | | | | | |
|---|--|--|---|---|---|---|--|---|---|
| | | захиргааны бүх шатны байгууллагад даалгав. | | | | | | | |
| 5 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандaa нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | Нийслэлийн нутгийн захиргааны 996 байгууллагын 14054 албан хаагч архив, албан бичиг хөтлөлтийн https://edoc.ulaanbaatar.mn/ системийг ашиглан тамга тэмдэг дарах эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр албан бичиг илгээж солилцдог бөгөөд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хоорондын албан бичгийн харилцааг 100% цахимжуулсан. Тус системийг ашиглан 2023 оны 5-р сарын байдлаар 111,623 албан бичгийг цахимаар солилцсон. | + | | | | + | |
| 6 | 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл | IX.1.4. "Car pooling service" буюу автомашин хуваалцах үйлчилгээний талаар судалж, нэвтрүүлэх арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, | Хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, тевлөрлийг сааруулах, авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны 2022 оны 01 дүгээр тогтоогоор байгуулагдсан "Зорчих хөдөлгөөний нэгдсэн систем"-ийн ажлын хэсгийн 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний | | + | + | | | + |

| | | | | | | | | | | | |
|---|--|---|--|---|--|--|--|--|--|---|--|
| | 2022-09-28 Дугаар 2022_47 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | телевлөгөөнд "Car pooling service" буюу автомашин хуваалцах үйлчилгээг тусгаж өгсөн бөгөөд техникийн даалгаврыг боловсруулж байна. | | | | | | | | |
| 7 | | IX.1.12. "Зам, тээврийн удирдлагын ухаалаг систем"-ийн бүрэлдэхүүн болох автотээврийн хэрэгслийн гэрчилгээг цахимжуулах ажлыг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулж, мөн оны 4 дүгээр сарын 3-ны өдрөөс дагаж мөрдүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ /RFID TAG/-г сууринуулах ажлын гүйцэтгэгчээр шалгарсан компанийтай гэрээ байгуулахаар ажиллаж байна. Нийслэлийн хэмжээнд 100 цэгээр дамжуулан 442477 ширхэг цахим гэрчилгээг тээврийн хэрэгсэлд 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сууринуулахаар төлөвлөж байна. | + | | | | | | + | |
| 8 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ашигладаг албан хэрэг хөтлөлт, архивын өдөр тутмын үйл ажиллагааг цахим хэлбэрт хөтлөн явуулах, хянах, удирдах, нэгдсэн арга зүйгээр хангах зорилгоор архив, албан бичиг хөтлөлтийн https://edoc.ulaanbaatar.mn/ системийг ашиглан нийслэлийн нутгийн захиргааны 996 байгууллагын 14054 албан хаагч тамга тэмдэг дарах эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр албан бичиг илгөож солилцдог богоод тус системийг ашиглан 2023 оны 5-р сарын | + | | | | | | + | |

| | | | | | | | | | | | | | | |
|--|--|---|---|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|
| | | хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | байдааар 111,623 албан бичгийг цахимаар солилцсон. | | | | | | | | | | | |
|--|--|---|---|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|

Нийт

| | | | | | | | | | |
|---|---|---|--|---|---|---|---|---|---|
| 6 | 1 | 1 | | 1 | 0 | 0 | 4 | 1 | 3 |
|---|---|---|--|---|---|---|---|---|---|

2023 онд байгууллагад хамааралтай тусгагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудын хэрэгжилтийн хувь:

100% -тай хэрэгжсэн **6** арга хэмжээ;

70%-тай хэрэгжсэн **1** арга хэмжээ;


30%-тай хэрэгжсэн **1** арга хэмжээ;

Хэрэгжилтийн дундаж хувь **87.5 %** байна.

ТАНИЛЦСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Д.САЙНХҮҮ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Г.ЭНХЗУЛ

ТАЙЛАН НЭГЛЭСЭН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН  Т.ОТГОНЖАРГАЛ